



ДАЛАЙВАН АУДИТ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” ТББ

2017 оны 12-р сарын 31-ний өдрөөр  
тасалбар болгосон санхүүгийн тайлан



 an independent member of  
**BAKER TILLY**  
INTERNATIONAL



## ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон  
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066  
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5  
Утас: 70005401, 70005404, 70005405  
Факс: +976-70005403  
Э.Шуудан: [info@dalaivanaudit.mn](mailto:info@dalaivanaudit.mn)  
Вэб хуудас: [www.dalaivanaudit.mn](http://www.dalaivanaudit.mn)

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ -ын Удирдах Зөвлөлд

##### *Бидний дүгнэлт*

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон гол чухал нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Яамны 385-р тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

##### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

##### *Хараат бус байдал*

Бид Олон Улсын Ёс зүйн Хорооноос гаргасан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-аас хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

##### *Бусад мэдээлэл*

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын жилийн тайланг хамааруулах бөгөөд үүнд санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлт тайлан багтаагүй. Аудиторын тайлан гарахаас өмнө Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын 2017 оны жилийн тайлан бэлтгэсэн.

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан (ХДС) нь “Хамтын ажиллагааны гэрээ”, Сангийн дүрмийн дагуу үйл ажиллагаагаа ил тод зохион байгуулж Сангийн удирдах зөвлөлөөс санхүүжүүлэхээр баталсан орон нутагт хэрэгцээтэй төсөл, хөтөлбөрүүдийг журмын дагуу санхүүжүүлэн, сангийн дүрэм, холбогдох журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

## Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага, төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоохоос шийдсэнээс бусад тохиолдолд, тасралтгүй байх зарчмын дагуу Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын үйл ажиллагааг зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх үүргийг хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагналыг байнга илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Байгууллагын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.



ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

		2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4.1	6,768,726.2	8,479,802.0
Авлага		-	-
Бараа материал		-	-
Урьдчилж төлсөн зардал		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		<b>6,768,726.2</b>	<b>8,479,802.0</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	4.2	14,360.0	64,508.3
Хуримтлагдсан элэгдэл-үндсэн хөрөнгө		(2,480.8)	(8,108.4)
Биет бус хөрөнгө (цэвэр)	4.3	-	1,655.7
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<b>11,879.2</b>	<b>58,055.6</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>6,780,605.4</b>	<b>8,537,857.6</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн өр төлбөр</b>			
Дансны өр	4.4	-	2,723,135.8
Татварын өр		-	505.8
Банкны богино хугацаат зээл		-	-
Урьдчилж орсон орлого		-	-
Бусад өр төлбөр		-	-
Эргэлтийн өр төлбөрийн дүн		-	<b>2,723,641.6</b>
<b>Цэвэр хөрөнгө</b>			
Хязгаарлалтгүй нөөц		-	-
Хуримтлагдсан үр дүн	4.5	6,780,605.4	5,814,216.0
Цэвэр хөрөнгийн дүн		<b>6,780,605.4</b>	<b>5,814,216.0</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>		<b>6,780,605.4</b>	<b>8,537,857.6</b>



Багалсан:

С.Эрдэнэбат  
Гүйцэтгэх захирал

Бэлтгэсэн:

Б.Батхуяг  
Ерөнхий нягтлан бодогч

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ

ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

		2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>	4.6		
Хөтөлбөр, төслийн орлого		10,024,900.0	12,024,650.0
Бэлэг, хандив, тусламжийн орлого		-	-
Бусад орлого		-	33,462.9
<b>Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн</b>		<b>10,024,900.0</b>	<b>12,058,112.9</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	4.7		
<b>Төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэлтийн зардал</b>		<b>4,018,415.4</b>	<b>12,100,935.0</b>
<b>Байгууллагад өгсөн хандив тусламж</b>		<b>33,000.0</b>	<b>368,125.8</b>
<b>Тэтгэлэгт хөтөлбөрийн зардал</b>		<b>-</b>	<b>112,982.9</b>
Цалин хөлс, шагнал		63,171.4	142,802.4
Нийгмийн даатгалын шимтгэл		6,948.9	15,919.5
Засвар үйлчилгээний зардал		635.0	115.0
Бичиг хэргийн зардал		3,972.8	7,197.1
Түрээсийн зардал		14,850.0	14,850.0
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал		2,449.4	3,122.7
Тээврийн зардал		91.6	7,780.4
Элэгдлийн зардал		2,480.8	5,761.9
Зар сурталчилгааны зардал		23,098.0	66,679.6
Шуудан, холбооны зардал		2,255.0	3,698.4
Хангамжийн материалын зардал		1,928.1	2,425.9
Сургалтын зардал		14,150.4	430.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		1,026.3	127,622.4
Хурал, семинарын зардал		30,682.6	37,438.0
Бусад зардал		-	6,615.3
<b>Үндсэн үйл ажиллагааны нийт зардал</b>		<b>167,740.3</b>	<b>442,458.6</b>
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>		<b>5,838,744.3</b>	<b>(966,389.4)</b>
<b>Үндсэн бус үйл ажиллагааны орлого ба зардал</b>			
Валютын ханшийн зөрүүний ашиг/(алдагдал)		-	-
Бусад орлого		-	-
<b>Үндсэн бус үйл ажиллагааны үр дүн</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН</b>		<b>5,838,744.3</b>	<b>(966,389.4)</b>

Баталсан:



С.Эрдэнэбат  
Гүйцэтгэх захирал

Бэлтгэсэн:



Б.Батхуяг  
Ерөнхий нягтлан бодогч

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	2016.12.31 мянган төгрөг	2017 оны туршид мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Хязгаарлалтгүй нөөц	-	-	-
Хязгаарлалттай нөөц			
Дахин үнэлгээний нэмэгдэл			
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц			
Хуримтлагдсан үр дүн	6,780,605.5	(966,389.4)	5,814,216.1
<b>ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ/ӨӨРЧЛӨЛТ</b>	<b>6,780,605.4</b>	<b>(966,389.4)</b>	<b>5,814,216.0</b>



С.Эрдэнэбат  
Гүйцэтгэх захирал

Бэлтгэсэн:

Б.Батхуяг  
Ерөнхий нягтлан бодогч

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН ТББ

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
<b>Үйл ажиллагааны орох мөнгөн гүйлгээ</b>		
Төсөл, хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	10,024,900.0	12,006,650.0
Бэлэг, хандив, тусламжаас хүлээн авсан мөнгө	-	-
Бусад үйл ажиллагаанд хүлээн авсан мөнгө	-	22,919.2
Үйл ажиллагааны нийт орох мөнгөн гүйлгээ	10,024,900.0	12,029,569.2
<b>Үйл ажиллагааны гарах мөнгөн гүйлгээ</b>		
Ажиллагчдад олгосон мөнгө	(63,171.4)	(133,104.8)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(6,948.8)	(26,147.5)
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	(67,931.0)	(61,226.5)
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	(27,116.7)	(31,380.4)
Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэгт төлсөн	(91.6)	(9,496.4)
Төсөл, хөтөлбөрт олгосон мөнгө	(4,051,415.4)	(10,021,295.6)
Төлсөн хүү	-	-
Төлсөн татвар	-	(1,807.4)
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	(96.5)
Үйл ажиллагааны нийт гарах мөнгөн гүйлгээ	(4,216,674.9)	(10,284,555.1)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,808,225.1</b>	<b>1,745,014.1</b>
<b>Хөрөнгө оруулалтын орох (гарах) мөнгөн гүйлгээ</b>		
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	-	-
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	(13,665.0)	(33,938.3)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	<b>(13,665.0)</b>	<b>(33,938.3)</b>
<b>Санхүүгийн орох (гарах) мөнгөн гүйлгээ</b>		
Банкнаас авсан зээл	-	-
Банкны зээлийн төлөлт	-	-
Хүүгийн орлого	-	-
Валютын ханшийн зөрүүний ашиг/(алдагдал)	-	-
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>5,794,560.1</b>	<b>1,711,075.8</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	974,166.1	6,768,726.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,768,726.2	8,479,802.0



Бэлтгэсэн:

Б.Батхуяг  
Ерөнхий нягтлан бодогч

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### Тодруулга (1) ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь 2015 оны 9-р сарын 23-ний өдөр No.8186995 регистрийн дугаар бүхий No.64947 дугаартай Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авснаар Төрийн бус байгууллагаар бүртгэгдэж, Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, Оюу Толгой ХХК-тай хамтран сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлтэй.

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ыг Удирдах Зөвлөл болон Удирдлагын баг удирдана. 2017 оны туршид дараах гишүүдтэй байсан.

#### Удирдах Зөвлөл

<u>Нэр</u>	<u>Албан тушаал</u>
Стивен Жонс	Удирдах Зөвлөлийн Дарга–Оюу Толгой ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал
Х. Сугир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
Н.Наранбаатар	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Засаг дарга
Б.Эрдэнэ-Очир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн ИТХ-ийн Ханбогд сумаас сонгогдсон төлөөлөгч
Майкл Гавин	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн Боловсон хүчин, бүтэц, зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер.
Д.Амарбаясгалан	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал
Ш.Байгалмаа	Удирдах Зөвлөлийн Гишүүн – Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер

#### Удирдлагын Баг

<u>Нэр</u>	<u>Албан тушаал</u>
С.Эрдэнэбат	Гүйцэтгэх Захирал
С.Болдмаа	Төслийн менежер
Б.Сугаржаргал	Төсөл хөтөлбөрийн ажилтан
Б.Батхуяг	Санхүүгийн ажилтан

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн албан ёсны хаяг:  
Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Голомт бизнес төв, 4 давхар 404 тоот тоот Утас/Факс:  
976-70533577/976-70533578, цахим шуудан: [www.goviinoyu.mn](http://www.goviinoyu.mn)

Бейкер Тилли Интернэйшнл (Baker Tilly International)-ийн Монгол Улсыг төлөөлөх хараат бус бие даасан гишүүн Далайван Аудит ХХК, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаагийн гудамж, өөрийн байр

"DALAYVAN AUDIT" Co., Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL



## **Тодруулга (2) ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ**

Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан гол нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг дор харуулсан. Эдгээр бодлогуудыг бүх цаг хугацаанд тогтвортой ашигласан.

### **2.1 Санхүүгийн тайлагналын суурь**

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар, мөнгөн сууриар бэлтгэгдсэн байна.

### **2.2 Тайлан бэлтгэсэн үндэслэл**

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Сангийн Сайдын 385-р тушаалаар батлагдсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар-ын дагуу бэлтгэгдсэн.

### **2.3 Санхүүгийн хэрэгслүүд**

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өр төлбөр, санхүүгийн орлого, зардлаас бүрдэнэ.

### **2.4 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим**

Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

### **2.5 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой гол шийдэл, төсөөлөл ба тооцоолол**

СТОУС-д санхүүгийн тайлан бэлтгэхийн тулд нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон төсөөллийг ашиглахыг шаарддаг. Мөн Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын удирдлага нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад өөрийн шийдлийг гаргадаг. ТББ-ын удирдлага бүх боломжтой мэдээлэл болон туршлага дээрээ суурилан гаргасан тооцоолол, төсөөлөл болон шийдлээ байнга үнэлж үздэг. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан тооцоолол нь бодит байдлаас зөрүүтэй байж болно.

### **2.6 Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл**

Санхүүгийн тайланг Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын бүртгэлийн валют болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний олз эсвэл гарзыг үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланд тусгагдана.

"DALAIWAN AUDIT" Co., Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

## Тодруулга (3) НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

### 3.1 Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүдэд дараах хэрэглүүрүүдийг хамруулна:

- Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
- Дансны ба бусад авлага
- Дансны ба бусад өглөг

#### Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

##### 3.1.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх бэлэн мөнгө, банканд байгаа мөнгө болон 3 сар хүртэл хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө багтана.

##### 3.1.2 Дансны ба бусад авлага

Авлагыг бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний зардлын нийлбэрээр анхлан хэмжинэ. Дараа үеүдэд нь үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үл хүлээн зөвшөөрөх, үнэ цэнэ буурах, хорогдуулгын хөтөлбөрийн үед үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан. Уг гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор "Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан" ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-аас жил бүр 5,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгохоор заасан. Гэхдээ Оюу Толгой ХХК нь санхүүгийн дэмжлэгийг жилийн туршид хэсэгчлэн шилжүүлэх, шилжүүлэх цаг хугацаатай холбоотой шийдвэрийг гаргахдаа Оюу Толгой ХХК болон ба Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан" ТББ-ын Удирдах зөвлөлтэй зөвшилцөж санхүүгийн дэмжлэгийг (эсвэл түүний зарим хэсгийг) өгч байх заалттай тул санхүүжилтийн авлага, орлогыг мөнгөн сууриар бүртгэдэг.

##### 3.1.3 Дансны өр ба хуримтлагдсан өр төлбөр

Ханган нийлүүлэгчээс нэхэмжлэгдсэн үед хүлээн зөвшөөрөх бараа эсвэл үйлчилгээнд төлөх дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

### 3.2 Санхүүгийн бус хөрөнгө

#### 3.2.1 Бараа материал

Бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлчилгээнд үзүүлэх хангамжийн зүйлс хамаарна.

Бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбогдон гарсан зардлуудыг бараа материалын өртөгт оруулж тооцдог. Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авсан үнэ, импортын хураамж болон бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас дараагийн үеүдэд тухайн аж ахуйн нэгжид нөхөн олгохоос бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээг худалдан авахтай шууд холбогдон гарах бусад зардлууд орно. Худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасаж худалдан авалтын өртгийг тодорхойлно.

Тайлант хугацааны эцэст бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлнэ. Ашиглалтад тавьж олгосон бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тооцно.

### 3.2.2 Үндсэн хөрөнгө

Тайлант үеийн эцэст өртгөөр илэрхийлэгдсэн үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр хэмжсэн. Түүхэн өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл компани тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг орлуулсан үед нь дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг дараах ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

<u>Ашиглалтын жил</u>	
Тавилга эд хогшил	10
Компьютер дагалдах хэрэгсэл	3

Тайлант хугацааны эцэст үндсэн хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг нягтлан үзэж шаардлагатай бол залруулна. Үндсэн хөрөнгийн дансны үнэ нь тооцсон нөхөгдөх өртгөөс их тохиолдолд түүнийг нөхөгдөх өртөг хүртэл нь бууруулна.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

### 3.2.3 Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулалд ба аливаа үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан алдагдлыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгүүдийг эдийн засгийн үр ашигтай хугацааных нь туршид хорогдуулах бөгөөд биет бус хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон шинж тэмдэг илэрсэн үед үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийнэ.

Биет бус хөрөнгийг шулуун шугамын арга ашиглан дараах хугацаанд хорогдуулна.

<u>Ашиглалтын жил</u>	
Smart balance pro санхүүгийн программ	5

### 3.2.4 Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөц

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч юм. Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч юм.

Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Хандивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд түр хугацаанд хязгаарлалт тавьсан бол уг зорилго эсвэл цаг хугацааг хангагдах үед орлого хүлээн зөвшөөрнө.
- Хандивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд аливаа хязгаарлалт тавиагүй бол нөөцийг олж авах үед орлого хүлээн зөвшөөрнө.

### 3.3 Санхүүгийн орлого, зардал

#### 3.3.1 Үйлчилгээний төлбөр болон бусад орлого

Орлогыг үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

Оюу Толгой ХХК-тай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу орж ирсэн санхүүжилтийн орлогыг дараах нөхцөл бүрдсэн үед хүлээн зөвшөөрнө:

- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай байх
- Балансын өдрөөр тухайн ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг бодитойгоор тооцох боломжтой байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал болон ажил гүйлгээг гүйцээхэд гарсан өртгийг найдвартай хэмжих боломжтой байх.

#### 3.3.2 Зардал хүлээн зөвшөөрөх

Зардлыг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрнө. Мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

### 3.4 Татварын бүртгэл

#### 3.4.1 Орлогын татвар

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь ашгийн төлөө бус байгууллага учраас орлогын татвар тооцогдохгүй.

#### 3.4.2 Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл

Төрийн бус байгууллагын ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу, хувь хүний орлогын албан татварыг “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тогтоосон хувь хэмжээгээр суутган авч харьяалагдах татварын хэлтэст төлж тайлагнана. Татварыг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэдэг.

Төрийн бус байгууллага нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг 11 хувиар тооцож, тухайн жилийн зардалд хүлээн зөвшөөрсөн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэдэг.

"DALAIWAN AUDIT" Co.,LLP  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

### 3.5 Холбоотой тал

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- (i) Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- (ii) Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,
- (iii) Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- (i) Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
- (ii) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй группийн нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
- (iii) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
- (iv) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,
- (v) Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн "ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө"-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болно.
- (vi) Байгууллагад (1)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
- (vii) (1), (1)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,
- (viii) Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах,

### 3.6 Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээх магадлалтай, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө.

Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Болзошгүй өр төлбөрийг тайлант хугацааны эцэст байгаа одоогийн үүрэг хариуцлагыг барагдуулахын тулд удирдлагын хийсэн шаардлагатай зардлын хамгийн сайн тооцооллын өнөөгийн үнэ цэнээр хэмжих бөгөөд төлөгдөх нь тодорхой болох хүртэл болзошгүй өр төлбөрийг зөвхөн тодруулна.

"DALAYVAN AUDIT" Co., Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

**Тодруулга (4) САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**4.1. Тодруулга-Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Бэлэн мөнгө:		
Төгрөг	20.0	534.2
Банкин дахь харилцах:		
Төгрөг	6,768,726.2	8,429,267.8
<b>Дүн</b>	<b><u>6,768,726.2</u></b>	<b><u>8,479,802.0</u></b>
	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Банкин дахь харилцах:		
Төгрөг		
(i) Хаан банк-5585698858	5,953,411.8	7,164,084.3
(ii) Хаан банк-5585644465	186,007.2	14,057.3
(iii) Хаан банк-5585673654	60,799.4	73,398.4
(iv) Хаан банк-5585672708	167,493.8	297,783.5
(v) Хаан банк-5585675200	200,498.0	481,025.0
<b>Дүн</b>	<b>6,568,210.2</b>	<b>8,030,348.5</b>
(vi) Хаан банк- хадгаламж 5585675222	200,496.0	448,919.3
<b>Дүн</b>	<b>200,496.0</b>	<b>448,919.3</b>
<b>Мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b><u>6,768,706.2</u></b>	<b><u>8,429,267.8</u></b>

- (i) Хаан банк дахь 5585698858 тоот төгрөгийн харилцах данс нь Оюу Толгой ХХК-аас төсөл, хөтөлбөрийн санхүүжилт хүлээн авч Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан төсөл хөтөлбөр болон Сангийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, бусад дэд дансуудад шилжүүлэх зориулалттай төслийн тусгай данс байна.

Уг данснаас төслийн санхүүжилт болон бусад төлбөр тооцоог хийхдээ “Төлбөр гүйцэтгэх зөвшөөрөл” тусгай маягт ашиглан төлбөрийг хийдэг байна. Ингэхдээ гэрээ, хэлцэл болон бусад санхүүгийн баримт материалыг үндэслэн Сангийн удирдлагын багийн зөвшөөрлөөр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нарт болон Сангийн үйл ажиллагааны дансуудад шилжүүлэг хийдэг байна.

- (ii) Хаан банк дахь 5585644465 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн Сангийн үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд ашигладаг дэд данс байна.

- (iii) Хаан банк дахь 5585673654 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг “Говийн Оюу- Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа төслийг санхүүжүүлэхэд ашигладаг дэд данс байна.

"DALAYVAN AUDIT" Co., Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

#### 4.1. Тодруулга-Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө (үргэлжлэл)

- (iv) Хаан банк дахь 5585672708 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн Өмнөговь аймаг болон бусад сумдын нийгмийн ажил, байгаль цаг уураас үүдэлтэй тулгарсан бэрхшээлийг даван туулах зэрэгт хандив, тусламж үзүүлхд ашигладаг дэд данс байна.
- (v) Хаан банк дахь 5585675200 тоот төгрөгийн харилцах данс нь зөвхөн зорилтод бүлгийн жижиг дунд бизнесийн зээлийг дэмжих зорилготой дэд данс байна
- (vi) Хаан банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн данс нь Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сангаас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулсан хадгаламж юм. Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны №03 тоот тогтоолоор баталсан “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Хойч үеийн төлөө сан, мөн Удирдах зөвлөлийн 2016 оны 9 сарын 19-ний өдрийн №05 тоот тогтоолоор баталсан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан”-ийн журмыг тус тус үндэслэн 2016 оны 12 сарын 20-ний өдөр Өмнөговь аймгийн Хаан банкны салбарт 100,000 ам.доллартай тэнцэх хэмжээний буюу 200,498.0 мянган төгрөгийн хадгаламжийг 1 жилийн хугацаатай, сарын 1.3 хувь (жилийн 16 хувь) хүү тооцуулж байх хадгаламжийн гэрээг байгуулсан. Талууд гэрээг жил бүр сунгалт хийж нийт 10 жилийн хугацаатай байхаар гэрээ байгуулсан байна.

Тайлант хугацаанд тус дансанд 248,447.3 мянган төгрөгийг хадгаламжийн эх үүсвэрт нэмж хуримтлуулаж, 32,079.7 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна.

“GOVIND OYU HOGLIYG DEMJIKH SAN” LLC  
CREDIT AND FINANCIAL MONITORING  
& APPRAISAL

#### 4.2.Тодруулга-Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт дүн
<b><u>Анхны өртөг:</u></b>					
<b>2016.12.31-ний үлдэгдэл</b>	<b>4,000.0</b>	<b>10,360.0</b>	<b>18,000.0</b>	<b>=</b>	<b>14,360.0</b>
Нэмэгдсэн:					
Худалдаж авсан	3,672.4	16,982.0	18,000.0	11,493.9	50,148.3
Хасагдсан:					
<b>2017.12.31-ний үлдэгдэл</b>	<b>7,672.4</b>	<b>27,342.0</b>	<b>18,000.0</b>	<b>11,493.9</b>	<b>64,508.3</b>
<b><u>Хуримтлагдсан элэгдэл:</u></b>					
<b>2016.12.31-ний үлдэгдэл</b>	<b>95.0</b>	<b>2,385.8</b>	<b>=</b>	<b>=</b>	<b>2,480.8</b>
Нэмж байгуулсан элэгдэл	399.8	4,648.7	-	579.1	5,627.6
Хасагдсан	-	-	-	-	-
<b>2017.12.31-ний үлдэгдэл</b>	<b>494.8</b>	<b>7,034.5</b>	<b>=</b>	<b>=</b>	<b>8,108.4</b>
<b><u>Үлдэгдэл өртөг:</u></b>					
<b>2016.12.31-ний үлдэгдэл</b>	<b>3,905.0</b>	<b>7,974.2</b>	<b>=</b>	<b>=</b>	<b>11,879.2</b>
<b>2017.12.31-ний үлдэгдэл</b>	<b>7,177.6</b>	<b>20,307.5</b>	<b>18,000.0</b>	<b>10,914.8</b>	<b>56,399.9</b>

"Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан" ТББ-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 12 сарын 8-ны өдрийн 15 тоот тушаалаар 2 хүний бүрэлдэхүүнтэй эд хөрөнгийн тооллого хийх комисс томилогдож тооллогыг 2017.12.11-нээс 13-ны хооронд тооллого хийсэн байна.

Тооллогоор илүүдэл болон дутагдал илэрээгүй байна.

ТОМ АССАУРАЙТИЙН СЭЛНЭР  
 & APPRAISAL



#### 4.3.Тодруулга-Биет бус хөрөнгө (цэвэр)

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Санхүүгийн программ хангамж	-	990.0
Төсөвийн программ		800.0
Хуримтлагдсан хорогдуулга	-	(134.3)
<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>=</b>	<b><u>1,655.7</u></b>

#### 4.4.Тодруулга-Өр төлбөр

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Дансны өглөг	-	2,723,135.6
Цалингийн өглөг		0.2
ХХОАТ-ын өглөг	-	505.8
<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>=</b>	<b><u>2,273,216.0</u></b>

#### 4.5 Тодруулга-Цэвэр хөрөнгө

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Хязгаарлалтгүй нөөц	-	-
Хязгаарлалттай нөөц	-	-
Хуримтлагдсан үр дүн	6,780,605.4	5,814,216.0
<b>Цэвэр хөрөнгийн дүн</b>	<b><u>6,780,605.4</u></b>	<b><u>5,814,216.0</u></b>

Хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан нөөц байхгүй.

#### 4.6 Тодруулга-Хандив тусламжын болон бусад орлого

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Оюу Толгой ХХК-аас өгсөн сайн дурын санхүүжилтын орлого	10,024,900.0	12,006,650.0
Хандиваар авсан хөрөнгийн орлого		18,000.0
Хүүний орлого		32,079.7
Оюутны сургалтын төлбөрийн буцаалтын орлого		1,383.2
<b>Нийт орлого</b>	<b><u>10,024,900.0</u></b>	<b><u>12,058,112.9</u></b>

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор "Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан" ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-аас жил бүр 5,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгохоор заасан.

#### 4.6 Тодруулга-Хандив тусламжын болон бусад орлого (үргэлжлэл)

Оюу Толгой ХХК-аас 2017 оны 11 сарын 27-ны өдөр land cruiser 76 маркийн автомашиныг үнэ төлбөргүй хандиваар өгснийг орлогоор бүртгэсэн.

Хаан банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн дансанд сарын 1.3 хувь (жилийн 16 хувь) хүү тооцуулж байхаар хадгалуулсан хадгаламжын мөнгөөс 32,079.7 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна.

#### 4.7 Тодруулга-Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний зардал

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Төсөл ,хөтөлбөрийн зардал	3,978,970.2	12,100,935.0
Хандив ба тусламжийн зардал	33,000.0	368,125.8
Оюутаны тэтгэлэгт хөтөлбөрийн зардал	39,445.2	112,982.9
<b>Нийт зардал</b>	<b>4,051,415.4</b>	<b>12,582,043.7</b>

Хамтын ажиллагааны гэрээний чиглэлийн дагуу Оюу Толгой ХХК-аас олгосон санхүүжилтийг дараах байдлаар зарцуулсаныг ангилж харуулбал.

Төслийн чиглэлээр	Зарцуулсан зардал: мянган төгрөг	
	2016.12.31	2017.12.31
(i) Нийгмийн дэд бүтэц, барилга	2,733,625.0	9,501,073.8
(ii) Байгаль орчин менежмент	282,863.9	145,944.3
(iii) Нийгэмд чиглэсэн сургалт, үйлчилгээ	171,598.0	1,426,432.5
(iv) Мал аж ахуй, бэлчээрийн менежмент	386,585.6	461,283.8
(v) Түүх соёлын өв, аялал жуулчлал	404,297.7	566,200.6
(vi) Хандив, тусламж	33,000.0	368,125.8
(vii) Тэтгэлэгт хөтөлбөр	39,445.2	112,982.9
<b>Дүн</b>	<b>4,051,415.4</b>	<b>12,582,043.7</b>

"DALAYVAN AUDIT" Co., Ltd.  
CERTIFIED ACCOUNTING & APPRAISAL

#### 4.7 Тодруулга-Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний зардал (үргэлжлэл)

Хамтын ажиллагааны гэрээний чиглэлийн дагуу тайлант онд санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрийн талаар түүвэрлэн харуулбал:

(i) **Нийгмийн дэд бүтэц, барилга:**


Өмнөговь аймгийн Ханбогд сумын 640 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 200 хүүхдийн цэцэцрлэгийн цогцолбор барилгын ажил.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Говийн Өгөөж ХХК

**Санхүүжүүлэх дүн:** 6,079,828,009 төгрөг

**Олгосон санхүүжилтын дүн:** 4,255,694,290 төгрөг

**Цогцолборын зураг:**



Өмнөговь аймгийн Ханбогд сумын Малын эрүүл мэндийн нэгдсэн төвийн барилга угсралтын ажил.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Билэгт Багана ХХК
<b>Санхүүжүүлэх дүн: 1,084,618,739 төгрөг</b>		
<b>Олгосон санхүүжилтын дүн: 1,030,387,803 төгрөг</b>		
<b>МЭМТөвийн зураг:</b>		



Өмнөговь аймгийн Манлай сумын Уурын зуухны барилга угсралтын ажил.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Нарны Цаг ХХК
<b>Санхүүжүүлэх дүн: 929,150,000 төгрөг</b>		
<b>Олгосон санхүүжилтын дүн: 743,320,000 төгрөг</b>		
<b>Уурын зуухны зураг:</b>		



Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Нийтийн тээврийн үйлчилгээг сайжируулах хөтөлбөр ажил.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Экологбус ХХК

Санхүүжүүлэх дүн: 350,000,000 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 175,000,000 төгрөг

Зураг:



(ii) Байгаль орчин менежмент:

Говийн ойн, төгөл хөтөлбөр ажил.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Бат Цайз Хоршоо

Санхүүжүүлэх дүн: 57,419,700 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 41,757,500 төгрөг

Зураг:



Хог хаягдлыг бууруулах цэмцгэр Даланзадгад хөтөлбөр ажил.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Түшиг Мандал ХХК

Санхүүжүүлэх дүн: 40,500,000 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 39,285,000 төгрөг

Зураг:



(iii) Нийгэмд чиглэсэн сургалт, үйлчилгээ:

Өмнөговь аймгийн нийт сумдын хэмжээнд сургууль болон цэцэрлэгийн багш нарт сургалт явуулах.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Поларис Боловсролын Академи ХХК

Санхүүжүүлэх дүн: 150,000,000 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 150,000,000 төгрөг

Зураг:



**(iv) Мал аж ахуй, бэлчээрийн менежмент:**

Зорилтод сумдад Шилмэл сүрэг бий болгох хөтөлбөр.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Өмнөговь аймаг ХААГазар

Санхүүжүүлэх дүн: 138,283,840 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 138,283,840 төгрөг

Зураг:



**(v) Түүх соёлын өв, аялал жуулчлал:**

Зорилтод сумдад Шилмэл сүрэг бий болгох хөтөлбөр.

Захиалагч	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч
Өмнөговь аймаг Засаг Даргын Тамгын Газар	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ	Улаанбаатар Телевиз ХХК

Санхүүжүүлэх дүн: 200,000,000 төгрөг

Олгосон санхүүжилтын дүн: 160,000,000 төгрөг

Зураг:



**(vi) Хандив, тусламж:**

Өмнөговь Аймгийн Засаг Даргын Тамгын Газраас аймгийн мал аж ахуйн салбарын 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтийг хүндрэлгүй даван туулгахад шаардлагатай 250,000,000 төгрөгийн өвөс, тэжээл бэтгэх зорилгоор Өмнөговь Аймгийн Хөгжил Хөрөнгө Оруулалтын Газарт хандив өгсөн.

**(vii) Тэтгэлэгт хөтөлбөр:**

“Говийн оюу- Оюутаны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд нийт 57 оюутанд 105,215,602 төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

**4.8 Тодруулга-Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал**

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Үндсэн ба нэмэгдэл цалин	63,171.4	142,802.4
Нийгмийн даатгалын шимтгэл	6,948.9	15,919.5
Удирдах зөвлөхийн хурлын зардал	30,682.6	37,438.0
Зар сурталчилгаа, хэвлэлийн зардал	23,098.0	66,679.6
Оффис түрээсийн зардал	14,850.0	14,850.0
Сургалтын зардал	14,150.4	430.0
Бичиг хэргийн зардал	3,972.8	7,197.1
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2,449.4	3,122.7
Элэгдлийн зардал	2,480.8	5,761.9
Шуудан холбооны зардал	2,255.0	3,698.4
Хангамжийн материалын зардал	1,928.1	2,425.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	1,026.3	-
Засварын үйлчилгээний зардал	635.0	115.0
Тээврийн зардал	91.6	7,780.4
Зөвлөх үйлчилгээний зардал	-	127,622.4
Хяналтын зардал	-	4,424.0
Бусад зардал	-	2,191.3
<b>Дүн</b>	<b><u>167,740.3</u></b>	<b><u>442,458.6</u></b>

**4.9 Тодруулга-Үйл ажиллагааны бус орлого**

	2016.12.31 мянган төгрөг	2017.12.31 мянган төгрөг
Хүүнийн орлого	-	33,462.9
<b>Дүн</b>	<b><u>=</u></b>	<b><u>33,462.9</u></b>

"DALAIYAN AUDIT" Co., Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL



#### 4.10 Тодруулга - Холбоотой тал

Холбоотой талын нэр	Харьяалал	Хамаарал	Ажил гүйлгээ
Оюу Толгой ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Үүсгэн байгуулагч	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
Өмнөговт аймаг, Хан богд сум бүсэд түншлэгч сум	Монгол улсын хуулийн этгээд	Хамтын ажилгааны гэрээний дагуу удирдан зохион байгуулагчид	Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хандив, дэмжлэг
Стивен Жонс	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн дарга	Хурал, уулзалт
Х. Сугир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Н.Наранбаатар	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Б.Эрдэнэ-Очир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Майкл Гавин	Австрали улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Д.Амар баясгалан	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Ш.Байгалмаа	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
С.Эрдэнэбат	Монгол улсын иргэн	Гүйцэтгэх захирал	Цалин

#### 4.11 Тодруулга-Болзошгүй өр төлбөр

2017 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

#### 4.12 Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Тайлант хугацаа дуусгавар болсноос хойш 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн тайланд нөлөөлөх аливаа үйл явдал гараагүй байна.

Аудитын тайланг, тодруулгын хамт монгол, англи хэлээр тус бүр 2 хувь бэлтгэсэн бөгөөд эдгээрт утгын зөрүү гарвал монгол эх хувийг баримтлах болно.



2018 оны 06 дүгээр сарын 04